

Хүүхдийн ядуурал, түүнийг хэмжих нь

МУИС-ийн ЭЗС-ийн ХАССТ-ийн судлаач Б. Наранчимэг

Манай улс нийгэм эдийн засгийн шинэ харилцаанд шилжин орсон 1990-ээд оноос хойшхи шилжилтийн үр нөлөөгөөр ажилгүйдэл, ядуурал, шилжих хөдөлгөөн, сургууль завсардалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд газар авсаар байна. Нийгмийн эдгээр үзэгдлүүд нь юу юунаас илүү хүүхдүүдийн эрх ашиг, ирээдүйд сөрөг нөлөө үзүүлж байна.

Манай улс нийгэм эдийн засгийн шинэ харилцаанд шилжин орсон 1990-ээд оноос хойшхи шилжилтийн үр нөлөөгөөр ажилгүйдэл, ядуурал, шилжих хөдөлгөөн, сургууль завсардалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд газар авсаар байна. Нийгмийн эдгээр үзэгдлүүд нь юу юунаас илүү хүүхдүүдийн эрх ашиг, ирээдүйд сөрөг нөлөө үзүүлж байна.

Хүн амын сургалт судалгааны төвөөс 2003 онд явуулсан “Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн” судалгааны мэдээлэлд үндэслэн хүүхдийн ядуурлыг тооцож үзэхэд: Нийт хүүхдүүдийн 38 хувь нь орлогын хувьд, 31 хувь нь нөхцөл байдал, хүртээмжийн хувьд, 2 хувь нь чадавхийн хувьд ядуу аж төрж байна. Ядуурлын асуудлууд хүүхдүүдийн хувьд хэрхэн давхцаж байгааг судалж үзэхэд нийт хүүхдийн 24 хувьд нь ядуурлын хоёроос гурван хүчин зүйл давхар тохиолдож байлаа. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын хүүхдүүдийн амьжиргааны түвшинг авч үзвэл, 12.9 хувь нь нэн ядуу, 25.1 хувь нь ядуу, 27.5 хувь нь ядуу бус доод, 20.3 хувь нь ядуу бус дунд, 14.1 хувь нь ядуу бус чинээлэг амьжиргаатай өрхөд амьдарч байна. Хүүхдүүдийн 30.9 хувь нь ямар нэг байдлаар боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй, түүнчлэн орон сууцны наад захын шаардлага хангахуйц тав тухтай нөхцөлд аж төрж чадахгүй байна.

1. Оршил

Сүүлийн 20 жилд дэлхийн эдийн засаг эрчимтэй хөгжхийн зэрэгцээгээр ядуучуудын тоо 1.5 тэрбумд хүрчээ. Өөрөөр хэлбэл, 4 хүн тутмын нэг нь ядуу амьдралтай байгаагийн 750 сая нь хүүхэд байна. Өдөр бүр амь зогоохын төлөө тэмцэж байгаа ядуурлын дүр төрх энэ дэлхийн харанхуй ангал болоод байна. Дэлхийн 4 үндэстэн бүрийн нэг нь ядуу амьдарч байгаа энэ үед боолчлол дэлхийн сая сая хүүхдийн амьдралын хэв шинжийг тодорхойлж байна. Ядуурлаас болж худалдагдсан, боолчлогдож байгаа, албадлагаар хөдөлмөр эрхэлж байгаа, хүчээр цэрэгт татагдсан, эсвэл хүчээр биеэ худалдаж байгаа болон мансууруулах бодис худалдаалж буй хүүхэд хичнээн байгааг тооцохын ч аргагүй¹.

Ядуурал, өрийн сүлжээнд автсан улс оронд хүүхэд эцэг эхийнхээ өрийг 10, 12 жил болсон ч төлж дуусдаггүй бөгөөд түүний дүү, бүр өөрийнх нь үр удамд өр шилжин гэр бүлийн мөнхийн боолчлол, ядуурал үүсдэг байна. Өөрөөр хэлбэл ядуурал нь хүүхдүүдэд эцэг, эхээс нь өвлөж ирдэг ажээ.

Манай улс нийгэм эдийн засгийн шинэ харилцаанд шилжин орсон 1990-ээд оноос хойшхи шилжилтийн үр нөлөөгөөр ажилгүйдэл, ядуурал, шилжих хөдөлгөөн, сургууль завсардалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд газар аваад байгаа билээ. Нийгмийн эдгээр үзэгдлүүд нь юу юунаас илүү хүүхдүүдийн эрх ашиг, ирээдүйд сөрөг нөлөө үзүүлж байна.

¹ НУБ-ын Хүүхдийн сан, □Дэлхийн хүүхдийн байдал, 2000 он□ илтгэл, Хүүхдийн сайн сайхны төлөө манлайлах нь, УБ 2001 он.

НХХЯ-ны захиалгаар ХАССТ-өөс 2003 онд хийж гүйцэтгэсэн □Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн□ судалгааны үр дүнгээс харахад 17 хүртэлх насны хүүхдүүдийн 37.9 хувь нь ядууралд өртөөд байна. Энэ нь бага тоо биш юм.

Эндээс хүүхдүүд ядууралд өртөөд байгааг хэрхэн тайлбарлах вэ? Ядуурал гэж чухам юу вэ? Ядуучуудын тоог хэрхэн тооцож, хэмжиж байна вэ? Хүүхдийн ядуурал 38 хувьтай байна гэдэг нь хэр үнэмшилтэй тоо вэ? гэх зэргээр ар араасаа цуварсан, уялдаа холбоо бүхий асуултууд урган гарч ирж байна. Эдгээр асуултуудад хариулахын тулд юуны өмнө ядуурлын тодорхойлолт, хэмжүүрүүдийн талаар нарийвчлан судалж үзэх шаардлагатай.

□Хүүхдийн ядуурал ба түүнийг хэмжих нь□ сэдэвт энэхүү ажлаар ядуурлын талаар ямар ойлголт, тодорхойлолтууд байдаг болон ядуурлыг хэмжихэд ямар арга, хэмжүүрүүдийг ашигладгийг судалж үзсний үндсэн дээр хүүхдийн ядуурлыг хэрхэн хэмжвэл зохих, тэрхүү хэмжүүр нь юу байж болох талаар аргачлал дэвшүүлж, мэдээллийн хоёрдогч эх үүсвэр буюу тоо мэдээлэлд үндэслэн хүүхдийн ядуурлыг хэмжихийг зорилоо.

2. Ядуурлын талаарх ойлголт, тодорхойлолтууд

Ядуурлыг судлахад гардаг гол бэрхшээлүүдийн нэг бол ядуурлыг тодорхойлох, хэмжих асуудал юм. Орчин үед хүний хөгжил, ядуурлын асуудлуудад ихээхэн анхаарал хандуулж, хэвлэж нийтлэх, судлах цар хүрээ өргөсөж байгаа хэдий ч ядуурлын талаарх нэгдсэн ойлголт хараахан төлөвшөөгүй байна.

Ядуурал нь юуны өмнө орлоготой холбоотой ойлголт юм. Орлого нь наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй л бол ядуу гэдэгт хамаарна. Тиймээс хүн амын дотор ядуурал нэмэгдэж байна гэж авч үзэхдээ ихэнхдээ хүн амын орлогын талаас нь тайлбарладаг². Гэтэл ядуурлыг зөвхөн орлоготой холбоотой бөгөөд орлогоор тодорхойлогдоно гэж үзэж болохгүй. Учир нь ядуурал эд хөрөнгө, орлого дутагдсанаас бий болдог үзэгдэл биш, түүнээс хавьгүй өргөн хүрээтэй ойлголт юм.

Ядуурал нь хувь хүн, айл өрхийн үндсэн хэрэгцээгээ хангахад зайлшгүй шаардлагатай байгаа хоол хүнс, хувцас болон бусад үйлчилгээ дутагдсанаас үүсч болдог. Тухайлбал, эрүүл мэндээ сахин хамгаалахад юм уу, зөв зохистой хооллох боломж олдохгүй байх, анхан шатны боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүй байх зэрэг нь ядуурлын нэг шинж юм³. Эдгээрээс харахад ядуурлыг дан ганц орлоготой холбоотой утгаар нь авч үзвэл өрөөсгөл ойлголт бий болгох ба олон талаас нь иж бүрэн тодорхойлох нь амьдралын олон өнгө аястай нийцнэ.

Олон улсын тодорхойлолтоор ядуурал нь зөвхөн эдийн засгийн асуудал биш бөгөөд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээний олон хүчин зүйлээр тодорхойлогддог.

Зарим судлаачдын үзэж байгаагаар ядуурлыг өргөн хүрээнд авч үзвэл дараах байдлаар тодорхойлж болох юм. Хэрэв хувь хүн, хүн амын нэг хэсэг нь нийгмийн хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн наад захын хэмжээнд хэрэглээгээ хангаж

² Б.Сувд, Эдийн засгийн өсөлт ба ядуурлын зарим асуудал, Эдийн засаг: онол, практик сэтгүүл, №1

³ Б.Вальтерс, Ф.Никсон, Б.Сувд, Монгол дахь ядуурал, Монголын эдийн засаг: Шилжилтийн эдийн засгийн гарын авлага, УБ-Манчестер 1999.

чадахгүй буюу тэр хэмжээнд бүрэн хооллож, хувцаслаж, орон гэртэй байж, эрүүл мэнд, боловсролын болон бусад үйлчилгээгээр хангагдаж чадахгүй бол түүнийг ядуу гэнэ (П.Таунсенд)⁴.

Нобелийн шагналт эдийн засагч Амартия Сэний хэлснээр: “... Ядуурлыг зөвхөн бага орлогоор бус, харин чадавхийн дутагдлаар илэрхийлэх нь зүйтэй.

Эндээс чадавхийн дутагдал буюу чадавхийн ядуурал гэсэн ойлголт гарч ирж байна. Энэ нь ихэвчлэн боловсрол болон эрүүл мэндийн дорой байдал зэрэгтэй холбоотойгоор бий болдог бөгөөд орлоготой хамааралтай ба хамааралгүй хоёр янз байдаг. Жишээлбэл, орлого багатай хүмүүс мэдлэг чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох, эзэмшсэн мэргэжлээ өөрчлөх, шинэ мэргэжил эзэмшихэд төлбөрийн чадвар дутагдалтайн улмаас чадварын ядууралд өртөж байна. Гэтэл орлоготой холбоогүй шалтгаанаар сургууль завсардах, сургуулиас гарах, сургуулийн насны хүүхэд сургуульд хамрагдахгүй байх, эсвэл архаг хууч өвчин болон ямар нэг байдлаар хөгжлийн бэрхшээлтэй/тахир дутуу байх нь мөн л чадавхийн ядууралд хүргэдэг.

Эдгээрээс гадна хүн нийгмийн амьтан болохынхоо хувьд нийгмийн ядууралд өртдөг байна. Энэ нь нийгмийн бусад гишүүнтэй харьцуулбал нийгмийн амьдралд оролцож чадахгүй байх, зүй бус ичмээр байдлаар амьдрах, өөрөөр хэлбэл нийгмийнхээ амьдралын доод хэмжээнээс доогуур байхыг хэлнэ. Тухайлбал, биеэ үнэлэгчид нийгмийн ядууралд өртөж байна, түүнчлэн шилжилтийн үеийн сөрөг нөлөөллөөр гудамжинд амьдарч буй тэнэмэл хүүхдүүд нэлээд бий болсон бөгөөд тэдгээр нь орлогын, чадавхийн болон нийгмийн ядууралд зэрэг өртөж байгаа юм.

Орлого бага, ур чадвар дорой байдлын хоорондын ялгааны тухай авч үзье. Ядуу хүмүүс хүч чадалгүй, аюултай, эмзэг байдлыг байнга мэдэрдэг. Өөрсдөө энэ байдлаа сайжруулах арга хэмжээ авах бус, харин өөрсдийн амьдралын талаар гаргах бусдын шийдвэрээс хараат амьдарч байна. Боловсрол муу, техникийн мэдлэг багатай байгаа нь тэднийг хойш нь татах нэг хүчин зүйл болж байна. Түүнчлэн эрүүл мэндийн байдал дорой тул бага цалинтай тогтвортой бус хөдөлмөр эрхлэхэд хүргэдэг. Иймээс нэн ядуу амьдралтай хүмүүст ядуурлаас гарах зам хомс байна. Энэ нь ужгирсан буюу үеэс үед дамжсан ядуурлыг бий болгож байгаа юм.

3. Ядуурлыг хэмжих ерөнхий аргууд

Дэлхийн дөрвөн үндэстэн бүрийн нэг нь ядуу амьдарч байгаа энэ үед дэлхий нийтээрээ ядуурлыг үнэн бодитоор хэмжиж тодорхойлох, шалтгааныг тодруулах, улмаар ядууралтай тэмцэхэд нэлээд анхаарал хандуулах болсон. Иймд дэлхий нийтээр хэрэглэгдэж буй ядуурлыг хэмжих аргууд болон Монгол улсын хэмжээнд ядуурлыг хэрхэн хэмжиж тодорхойлж ирсэн талаар товч авч үзье.

Орлого нь ядуурлыг хэмждэг үндсэн хэмжүүр боловч орлогод суурилсан ядуурлыг хэмжих аргууд нь орлогын бус хүчин зүйлс, тухайлбал боловсрол, эрүүл мэнд гэх мэтийг орхигдуулах хандлагатай байдаг⁵.

⁴ МУИС, Эдийн засгийн онолын тэнхим, □Өрхүүдийн ядуурах эмзэг байдлын судалгаа□, Улаанбаатар 2003 он.

⁵ НҮБ-ын Хүн амын сан, Дэлхийн хүн амын байдал 2002 онд, □Хүн ам ба ядуурал□, Улаанбаатар 20-р тал 2002 он.

Эдийн засгийн өсөлт өөрөө ядуурлыг арилгаж чадахгүй. Өөрөөр хэлбэл, хөрөнгө, нөөц баялаг нэмэгдэхийн хэрээр ядуусын амьдрал тэр хэмжээгээр сайжирна гэсэн ойлголт нь бодит амьдрал дээр тэр бүр нийцэхгүй байна. Учир нь ядуучууд хөрөнгө мөнгөөр гачигдахаас гадна эх үүсвэр, боломж, үйлчилгээгээр гачигдаж байдаг. Тиймээс сүүлийн жилүүдэд орлогын ядуурлыг эдийн засгийн эмзэг байдалтай холбон өргөн хүрээнд авч үзэх хандлагатай болсон бөгөөд хэд хэдэн үзүүлэлтүүдийг цогц байдлаар авч үзэж ядуурлыг хэмжиж байгаа юм. Энэ нь хувь хүмүүс болон гэр бүл эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан ажилгүйчүүдийн эгнээнд орж, эрүүл мэнд нь доройтох зэргээр ядуурал уруу түлхэгдэн орж байгаагаар тайлбарлагдаж байна.

Хүмүүсийн эрүүл мэнд, боловсрол, жендэрийн харилцаа, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэрэг нь сайн сайхан аж амьдралыг дэмжих, эсвэл доройтуулах ба ядуурлын хүрээ хязгаарыг тодорхойлоход тус болдог. Ядуурлаас гарах явдал хувь хүний өөрийн чадварыг сайжруулах, түүнд бүх төрлийн эх үүсвэр хүртэх боломжийг нэмэгдүүлэх, үүнийг дэмжих орчин механизмуудыг бүрдүүлэхээс шууд хамаарна.

Дэлхийн олон оронд хэрэглэгдэж буй ядуурлыг хэмжих, түүнд үнэлгээ өгөх аргууд нь ерөнхийдөө дараах үндсэн гурван хэсэгт ангилагдаж байна⁶. Үүнд:

- ◆ Ядуурлын шугамыг тодорхойлох замаар энэ шугамнаас доогуур хэрэглээтэй өрх, хүн амын талаарх янз бүрийн үзүүлэлт гаргах
- ◆ Хүмүүс өөрсдөө оролцож айл өрхүүдийг чинээлэг байдлаар жагсаах замаар оролцооны болон хурдавчилсан аргаар үнэлгээ хийх
- ◆ Тоо болон чанарын янз бүрийн үзүүлэлт ашиглан ядуурлын индекс үзүүлэлт тооцох

Ядуурлын шугамд тулгуурлан өрхийн зардлаар тооцох:

Дэлхий нийтээр өргөнөөр ашигладаг ядуурлыг тодорхойлох нэг арга нь өрхийн нийт зардлыг өрхийн амьжиргааны стандарт түвшинтэй уялдуулах арга юм. Үндэсний түвшинг төлөөлөх чадвар бүхий судалгааны, тухайлбал Амьжиргааны түвшинг тогтоох судалгааны тусламжтайгаар ядуурлын шугамыг тодорхойлж, улмаар ядуурлын хүрээг тооцно. Өрхийн орлого ам бүлийн наад захын хэрэглээг хангаж чадаж буй эсэхийг тодорхойлохын тулд хүнс, үйлчилгээ гэх мэт бараа үйлчилгээнээс бүтсэн хэрэглээний сагсыг орон нутгийн үнэлгээгээр үнэлж бүрдүүлдэг. Энэхүү сагсны үнийг аливаа хүний наад захын хэрэгцээг хангахад хүрэлцээтэй гэж үзэн ядуурлын шугам гэж нэрлэдэг. Хэрэв тухайн өрхийн нэг хүнд ногдох орлого ядуурлын шугамнаас доогуур бол тухайн өрх ба өрхийн гишүүд ядууд тооцогддог. Гэхдээ энэхүү тооцооны үнэн зөвийг шалгахад хэцүү.

Оролцооны болон хурдавчилсан аргаар хийх үнэлгээ:

Энэ хоёр аргачлалын үед нийгмийн гишүүдийг өөрсдийг нь оролцуулах замаар үнэлгээ хийдэг. Эхний арга буюу оролцооны аргаар үнэлгээ хийхдээ маш олон тооны хүмүүсийг хамруулж, нэлээд урт хугацаанд хийдэг бөгөөд гол зорилго нь сонгож авсан бүлэг хүмүүсээ чадавхжуулахад оршдог. Харин хурдавчилсан аргаар үнэлгээ хийхэд маш богино хугацаанд урьдчилан бэлтгэсэн хөтөлбөрөөр мэдээлэл

⁶ НУБ-ын Хүн амын сан, Дэлхийн хүн амын байдал 2002 онд, □Хүн ам ба ядуурал□, Улаанбаатар 2002 он. 24-р тал.

цуглуулдаг бөгөөд ихэвчлэн нэг тосгон эсвэл сууринд нэг өдөр зарцуулдаг. Хөгжлийн хөтөлбөрүүд дээрх хоёр аргыг хоёуланг ашиглаж ядуучуудад зориулсан үйлчилгээ төлөвлөн зохион байгуулахад ашигладаг. Гэвч хоёр арга хоёулаа дутагдалтай талуудтай. Учир нь үнэлгээний үр дүн тухайн бүлэг хүмүүсийн бодол санааны үр дүн учраас улс орны хэмжээнд өөр хөтөлбөрүүдтэй болон байршлаар гаргасан мэдээлэлтэй харьцуулахад хэцүү байдаг. Олон улсын түвшинд харьцуулалт хийхэд бүр ч төвөгтэй. Энэ аргачлалаар нэг дүүргийн/сумын бүлэг хүмүүс ядуу гэж тодорхойлогдсон байхад улс орныхоо доторх бусад бүс нутагтай харьцуулахад ядуу гэж тодорхойлохооргүй ч байж болно. Оролцооны аргаар үнэлгээ хийхэд маш их ур чадвартай хүмүүс удирдан явуулах шаардлагатай.

Хэд хэдэн үзүүлэлтэд суурилсан ядуурлын индекс:

Тооцоход хүндрэлтэй биш, байгаа мэдээлэлд тулгуурлан тооцож болох хэд хэдэн үзүүлэлтэд үндэслэн ядуурлын хүчин зүйлд үнэлгээ өгч болно. Жигнэх замаар эдгээр үзүүлэлтээс индекс гарган авдаг. Өмнөд болон Зүүн Өмнөд Азийн санхүүгийн олон жижиг байгууллага ядуучуудад зориулсан санхүүгийн үйлчилгээг төлөвлөхдөө орон сууцны индекс ашигладаг. Хана, шалны талаарх үзүүлэлтүүдийг үзлэгийн үр дүнд хялбархан тогтоож болох ба алдаа бага гарах магадлалтай. Сонгон авч буй үзүүлэлтүүдийг тухайн орон нутгийн онцлогт тохируулан өөрчлөх боломжтой. Үзүүлэлт болгонд өгч буй жин магадгүй бага зэрэг санамсаргүй дур мэдэн ойлгож буй мэт санагддаг. Орон сууцны индекс бол ядуурлын ганц хүчин зүйлийг илэрхийлнэ. Нэлээд өргөн хэмжээний дүр зургийг харуулахын тулд индекс нь ядаж дөрвөн асуудлыг тусгасан байх хэрэгтэй. Тухайлбал, хүний нөөц, орон сууц, хүнсний аюулгүй байдал, өрхийн өмч хөрөнгө гэх мэт.

4. Монгол улсад ядуурлыг хэмжиж, тодорхойлж ирсэн аргачлалууд

Шилжилтийн үеийн нөлөөгөөр олон айл өрхийг дайрсан ядуурал нь өдрөөс өдөрт нэмэгдэж манай улсын тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Тиймээс ядуурлыг бууруулах бодлого чухлаар тавигдах болов. Үүний тулд ядуучуудын тоо, тэдгээрийн дүр зургийг тодорхойлох мэдээлэл чухал болж, улмаар ядуурлыг хэмжиж тогтоох нь засгийн газрын нэн тэргүүний зорилго болсон юм.

1991 онд Үндэсний Статистикийн Газар (ҮСГ) болон бусад (Үндэсний хөгжлийн газар, Монголын Үйлдвэрчний холбоо, Эрүүл мэндийн яам г.м) байгууллагын ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, амьжиргааны наад захын хэрэгцээг хангахад зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний сагсны өртгийг үндэслэн ядуурлын албан ёсны шугам буюу амьжиргааны баталгаажих доод түвшинг жил бүр тогтоодог болсон⁷.

Монгол улсын засгийн газар ядуурлын талаарх тоо, мэдээллийн чанар, холбогдох тоо мэдээллийг цуглуулж боловсруулах арга зүйн чадавхийг сайжруулсан томоохон хэмжээний судалгааны төслүүдийг хэрэгжүүлсэн нь өрхүүдийн амьжиргааны түвшнийг тодорхойлох 1995, 1998, 2003 оны судалгаанууд байв. Эдгээр судалгаануудаар ядуурлыг хэмжихдээ хэрэглээний зардалд тулгуурлан

⁷ ҮСГ, Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998.

тооцсон ба ядуу хүн амыг ядуу бус хүн амаас ялган авч үзэхдээ амьжиргааны түвшний доод хэмжээ буюу ядуурлын шугамыг ашигласан юм.

Түүнчлэн ядуурлын түвшинг хэмжих тогтолцоонд 1998 онд хоёр томоохон өөрчлөлт гарав. Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлаас "Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай" хуулийг батлан гаргаж, үндэсний хэмжээнд ядуурлын түвшинг тодорхойлох эрх үүргийг Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ҮСГ-т шилжүүлсэн. Хоёрдугаарт, ҮСГ 1999 оноос эхлэн 1998 оны Амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааны (АТТС) үр дүнд тулгуурлан амьжиргааны доод түвшинг тухайн үеийн инфляцийн түвшинтэй уялдуулан засварлаж, жил бүр шинэчлэн тогтоож байхаар болсон⁸. Ийнхүү тогтоохдоо өрхийн орлого, зарлагын судалгааг хийдэг болсон байна.

Энэ бүх хугацаанд ядуурлыг хэмжих арга нь ядуурлын шугам болж байсан бол 2000 онд хүн амын амьжиргааны түвшинг оролцооны аргаар тодорхойлох судалгаа явуулснаар ядуурлыг хэмжих арга зүйд нэг чухал алхам болсон.

2004 онд Хүн амын сургалт судалгааны төвөөс хийсэн "Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн" судалгаагаар ядуурлыг дан ганц орлоготой холбон авч үзэж байсан уламжлалыг эвдэн ядуучуудыг орлого, нийгмийн үйлчилгээнээс хүртэж буй байдал, нийгмийн оролцоо гэсэн гурван өнцгөөс харж, өргөн хүрээнд тодорхойлсон. Энд орлогын ядуурлыг авч үзэхдээ ядуурлын шугамыг ашигласан ба АТТС-аар тооцдог ядуурлын хэмжүүрүүдийг (ядуурлын хамралтын индекс, гүнзгийрэлтийн индекс, жини коэффициент г.м) мөн авч үзжээ. Харин хүртээмжийн болон нийгмийн оролцооны ядуурлыг хэмжихдээ хэд хэдэн үзүүлэлтүүдийн индекс ашигласан байна.

Эндээс, 1990-ээд оноос хойш Монгол улсын Засгийн газраас ядуурлын асуудалд анхаарлаа хандуулах болсноор ядуурлыг хэмжих, тодорхойлох арга зүй жил ирэх тусам өөрчлөгдөн шинэчлэгдсээр ирсэн бөгөөд дээр дурьдсан дэлхий нийтээр түгээмэл хэрэглэдэг ядуурлыг хэмжих гурван аргыг гурвууланг ашиглах болсон нь харагдаж байна.

5. Хүүхдийн ядуурал, түүнийг хэмжих нь

Судлаачдын үзэж байгаагаар ядууралд өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдүүд болон өндөр настангууд илүүтэй өртдөг байна. Эндээс хүүхдийн ядуурлын талаар авч үзье.

Ядуурлын талаарх тогтсон нэг тодорхойлолт байдаггүйн нэгэн адил хүүхдийн ядуурлын талаар мөн тогтсон ойлголт байдаггүй байна. Гэхдээ хүүхдийн ядуурлыг ихэвчлэн орлого багатай өрхөд амьдарч буй байдал болон тэгш бус боломжтой холбон тайлбарладаг.

Манай улсын хувьд хүүхдийн ядууралтай холбоотой тоо мэдээлэл, эрдэм шинжилгээний бүтээл бараг байхгүй. "Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн" судалгаагаар 17 хүртэлх насны хүн амын 37.9 хувь нь орлогын хувьд ядуу, 22.7 хувь нь хүртээмжийн хувьд ядуу, 24.9 хувь нийгмийн оролцооны хувьд ядуу гэсэн тооцоо гаргасан нь магадгүй хүүхдийн ядууралтай холбоотой ганц мэдээлэл болж байна. Гэхдээ энэхүү хүртээмжийн болон нийгмийн оролцооны

⁸ Кийт Гриффин, Монгол улсад ядуурлыг бууруулах нь , 2003 он.

ядуурлын индексийг тооцоход авч үзсэн үзүүлэлтүүд нь хүүхдийн ядуурлыг тодорхойлоход оновчтой эсэх нь эргэлзээтэй.

Өрхийн орлого бага байх нь хүүхдийг ядууралд хүргэх гол хүчин зүйл боловч өндөр эрсдэл бүхий нөхцөл байдал, тухайлбал, ажилгүйдэл, гэмт хэрэг, архидалт, гэр бүл салалт зэрэг нь хүүхдийн ядууралтай салшгүй холбоотой⁹. Эдгээр нь ихэвчлэн эцэг эх болон хүүхдийг хүрээлж буй орчноос хамааралтай нөхцөл байдлууд юм.

Хүүхэд буюу 18 хүртэлх насны хүн ам нь ихэвчлэн эцэг, эх, асран хамгаалагчаасаа хараат байдлаар өсөн торниж, хөгжиж, ирээдүйд улс орныг авч явах гол хүчин болох хувь хүн болон төлөвшдөг. Энэ нь хүүхдүүд эцэг, эхийнхээ хувь заяатай салшгүй холбоотой ба дээр авч үзсэнээр хэрэв эцэг, эх нь ядуу бол ядуу байна гэсэн үг юм. Ядуу өрхөд амьдарч буй хүүхдүүд орлого багатайгаас үүдэн сурах бичиг, хичээлийн хэрэгслээ авч чадахгүй, улмаар боловсролын үйлчилгээнээс хүртэж чадалгүй сургууль завсардах явдал түгээмэл байна. Түүнчлэн ядуугийн хүлээнээс болж хүүхдүүд хоол тэжээлээр дутагдан өвчлөмтгий болох улмаар ядуу эцэг, эхчүүд нь хүүхдүүдээ эрүүл мэндийн чанартай сайн үйлчилгээнд тэр бүр хамруулж чадахгүй явдал түгээмэл байдаг. Мөн ядуурлаас болж хүүхдүүд өрхийн амьжиргаандаа тус нэмэр болохын тулд, басхүү дутагдаж буй өөрийн хэрэгцээгээ хангахын тулд хөдөлмөр эрхэлж байгаа нь манай нийгмийн далд биш ил үзэгдэл болоод байгаа билээ. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд нь ихэвчлэн албан бус салбарг хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд тэдний хөдөлмөрийн нөхцөл байдалд хяналт тавих боломж нөхцөл хязгаарлагдмал байна. Албан бус салбар дахь хүүхдүүдийн хөдөлмөр нь ихэвчлэн цаг агаарын хүнд бэрх нөхцөлд, эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй орчинд, хүүхдүүдийн нас, эмзэгхэн биед ахадсан, хуулиар заагдсан язгуур эрх ашгийг нь хөндсөн хэлбэртэй байдаг.

Энэ бүхнээс харахад хүүхдүүдийн ядуурлыг дан ганц орлого, амьжиргааны түвшнээр тодорхойлолгүй сургууль завсардалт буюу боловсролоос хүртэх хүртээмж, эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэх хүртээмж, нийгэмд эзлэх байр суурь буюу язгуур эрх ашиг зөрчигдөж байгаа эсэх зэргээр илэрхийлж болох юм. Хэрэв эдгээр үзүүлэлтүүдийг чадавхийн дутагдал гэсэн ойлголтын хүрээнд авч үзээд хүүхдийн ядуурлыг тодорхойлоход индекс үзүүлэлт байдлаар хэрэглэвэл дээр дурьдсан ядуурлын түвшин (38 хувь) хүүхдүүдийн хувьд илүү өндөр гарч болох магадлалтай. Учир нь амьжиргааны түвшин харьцангуй гайгүй айл, өрхийн хүүхдүүд амьжиргааны түвшнээс бусад шалтгаанаар суурь боловсрол эзэмшиж чадахгүй, түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж чадахгүй байх тохиолдол цөөнгүй байдаг. Мөн бусдын дарамт, шахалт, хүчирхийлэлд өртөж байгаа хүүхдүүд ч гэсэн амьжиргааны түвшний хувьд ядуу бус байсан ч эрх ашгаа хөндүүлж, хязгаарлагдмал байдалд байгаагаараа ядуу болж болно.

Иймээс хүүхдийн ядуурлыг хэмжихдээ нэлээд няхуур хандаж, үзүүлэлтүүдийг зөв сонгох нь хүүхдийн ядуурлын түвшинг бодитойгоор тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Хүүхдийн ядуурлыг орлого, боломж буюу хүртээмж, чадавхи болон нийгмийн ядуурал гэсэн хэд хэдэн өнцгөөс харж, хэмжиж болно.

⁹ HM Treasure, Child poverty review, 2004. p 9-15.

Орлогын ядуурал: Энд, хүүхэд орлого багатай буюу ядуу өрхөд амьдарч буй эсэх талаарх үзүүлэлтийг авч үзнэ. Хэрэв ядуу өрхөд амьдардаг бол тухайн хүүхэд ядууд тооцогдоно.

Боломж, нөхцөл байдлын ядуурал буюу хүртээмжийн ядуурал: Боломж, нөхцөл байдлын ядуурлыг тодорхойлохдоо сууцны ахуйн нөхцөл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэх бүлэг үзүүлэлтүүдийн нэгдсэн индексийг авч үзэж болох юм¹⁰. Үүнд дараахь 6 хувьсагчийг орууллаа.

- ◆ X_1 - Сууцны төрөл,
- ◆ X_2 - Цахилгааны эх үүсвэр,
- ◆ X_3 - Ундны усны эх үүсвэр,
- ◆ X_4 - Бие засах газрын төрөл,
- ◆ X_5 - Ерөнхий боловсролын сургуулиас алслагдсан байдал,
- ◆ X_6 - Шаардлагатай үед эмч, эмнэлгийн байгууллагаас тусламж авах боломжтой эсэх.

Энд, дараахь нөхцөлд **ядууд тооцогдоно**. Үүнд:

- ◆ Ахуйн нөхцлийг илэрхийлэх 4 хувьсагчид эерэг хариулт өгсөн боловч боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэх боломжийг илэрхийлсэн 2 хувьсагчид сөрөг хариулт өгсөн,
- ◆ Сүүлийн 2 хувьсагчид эерэг хариулт өгсөн боловч ахуйн нөхцөл нь дорой,
- ◆ Сууцны нөхцлийг тодорхойлох үзүүлэлтүүдээс хоёр ба түүнээс дээш үзүүлэлт нь сөрөг бөгөөд эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээний хүртээмжийн аль нэг нь хязгаарлагдмал тохиолдлууд багтана.

Бусад бүх хувилбаруудад **ядуу бус** гэж авч үзнэ.

Чадавхийн ядуурал: Хүүхдийн чадавхийн ядуурлыг тодорхойлохдоо эрүүл мэнд болон мэдлэг боловсролын хувьд байгаа бүх потенциалыг бүрэн ашиглах боломжгүй болон нийгэм, гэр бүлийн амьдралд бусадтай эрх тэгш оролцдог эсэхийг илэрхийлэх бүлэг үзүүлэлтүүдийн багц индексийг авч үзэж байна. Үүнд дараахь 5 хувьсагчийг оруулав.

- ◆ X_1 - Сургуулиас завсардсан эсэх,
- ◆ X_2 - Ямар нэг архаг хууч өвчинтэй эсэх,
- ◆ X_3 - Хөгжлийн бэрхшээлтэй эсэх,
- ◆ X_4 - Анги, хамт олны ажилд оролцдог эсэх,
- ◆ X_5 - Бусдын зүгээс ямар нэг дарамт, хүчирхийлэлд өртдөг эсэх.

Өөрийгөө хөгжүүлэх, эрүүл мэндээ сахин хамгаалах, бусдад өөрийгөө нээж, таниулах, эрх ашгаа хамгаалах чадваруудыг илэрхийлсэн эдгээр үзүүлэлтүүд нь хүүхдийн хувьд ижил ач холбогдолтой гэж үзэн индексийг тодорхойлохдоо үзүүлэлт тус бүрд жин ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Эдгээр таван үзүүлэлтийн гурав ба түүнээс дээш үзүүлэлтэд сөрөг хариулт өгсөн бол тухайн хүүхдийг чадавхийн хувьд ядууд тооцно.

¹⁰ ХАССТ-өөс хийсэн Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн судалгаанд хүртээмжийн ядуурлыг тодорхойлсон аргачлалаас иш татаж зарим нэг үзүүлэлтийг өөрчлөн нөхцөл байдлын ядуурлыг тодорхойлсон.


6. Улаанбаатар хотын хүүхдийн ядуурлын төлөв байдал

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны захиалгаар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Хүн амын сургалт судалгааны төвөөс 2003 онд явуулсан □Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн□ судалгааны мэдээлэлд үндэслэн хүүхдийн ядуурлыг тооцов.

1989 онд тунхагласан НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, 1999 онд баталсан ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хөдөлмөрийн конвенц (182)-д □18-аас доош настай хүн амыг хүүхэд гэнэ□ гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолтод тулгуурлан судалгаанд хамрагдсан 18-аас доош насны хүн амын мэдээлэлд үндэслэж хүүхдийн ядуурлыг хэмжив.

Орлогын ядуурал:

Улаанбаатар хотын хүүхдүүдийн 38 хувь нь орлогын хувьд ядуу байна.



Тэдний амьжиргааны түвшинг □Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн□ судалгаанд ашигласан ангиллаар авч үзвэл, 12.9 хувь нь нэн ядуу, 25.1 хувь нь ядуу, 27.5 хувь нь ядуу бус доод, 20.3 хувь нь ядуу бус дунд, 14.1 хувь нь ядуу бус чинээлэг амьжиргаатай өрхөд амьдарч байна.

Нөхцөл байдлын ядуурал:

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 30.9 хувь нь хүртээмжийн хувьд ядуу гэсэн ангилалд багтаж байна. Энэ нь Улаанбаатар хотын хүүхдүүдийн 30.9 хувь нь ямар нэг байдлаар боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй, түүнчлэн сууцны наад захын шаардлага хангахуйц тав тухтай нөхцөлд аж төрж чадахгүй байна гэсэн үг юм.

Чадварын ядуурал:

Судалгаагаар хүүхдүүд олон нийтийн ажилд оролцдог эсэх талаар болон бусдын зүгээс ямар нэг дарамт, шахалт, хүчирхийлэлд өртдөг эсэх талаарх мэдээлэл цуглуулагдаагүй учраас байгаа мэдээлэлд үндэслэн бусад гурван үзүүлэлт болох сургуулиас завсардсан, архаг хууч өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй гэсэн мэдээллээс

индекс зохиож чадавхийн ядуурлыг тодорхойллоо. Ийнхүү тодорхойлж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн ихэнх (98.3 хувь) нь чадавхийн хувьд ядуу бус гэсэн үр дүн гарч байна. Чадавхийн ядуурлыг насны бүлгийн хувьд авч үзэхэд 6-17 насны хүүхдүүд 0-5 насны хүүхдүүдийг бодвол чадавхийн ядууралд илүүтэй (4 дахин) өртсөн байв.

Хүүхдийн ядуурлын дүр төрх:

Нийт хүүхдүүдийн 38 хувь нь орлогын хувьд, 31 хувь нь нөхцөл байдал, хүртээмжийн хувьд, 2 хувь нь чадавхийн хувьд ядуу байна.

Ядуурлын асуудлууд хүүхдүүдийн хувьд хэрхэн давхцаж байгааг судалж үзэхэд нийт хүүхдийн 24 хувьд нь ядуурлын хоёроос гурван хүчин зүйл давхар тохиолдож байлаа.

Ашигласан материал

1. Б.Сувд, “Эдийн засгийн өсөлт ба ядуурлын зарим асуудал”, Эдийн засаг: онол, практик сэтгүүл, ¹¹
2. Б.Вальтерс, Ф.Никсон, Б.Сувд, “Монгол дахь ядуурал”, Монголын эдийн засаг: Шилжилтийн эдийн засгийн гарын авлага, УБ-Манчестер 1999.
3. Кийт Гриффин, 2003. “Монгол улсад ядуурлыг бууруулах нь”. Австрали, Соут Вуд Пресс
4. МУИС-ын Эдийн засгийн онолын тэнхим, “Өрхүүдийн ядуурах эмзэг байдлын судалгаа”, Улаанбаатар 2003 он.
5. НҮБ-ын Хүн амын сан, “Дэлхийн хүн амын байдал 2002 онд” илтгэл, Хүн ам ба ядуурал, Улаанбаатар 2002 он.
6. НҮБ-ын Хүүхдийн сан, “Дэлхийн хүүхдийн байдал, 2000 онд” илтгэл, Хүүхдийн сайн сайхны төлөө манлайлах нь, УБ 2001 он.
7. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монгол улсын Засгийн газар, 2003. “Монголын хүний хөгжлийн илтгэл, 2003”, Улаанбаатар, Монгол
8. HM Treasure, Child poverty review, 2004. p 9-15.
9. Үндэсний статистикийн газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, “Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998”, Улаанбаатар 1999 он.
10. Үндэсний статистикийн газар, Дэлхийн банк, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа, 2003-2004 он”, Улаанбаатар 2004 он.
11. Хүн амын сургалт судалгааны төв, НХХЯ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, “Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн” судалгааны тайлан, Улаанбаатар 2004 он.